



**УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ**

2020 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/41

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2, 3 дугаар хэсгийн 3.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийтийн эзэмшлийн гудамж, цэцэрлэгийн ногоон байгууламжийн арчилгааны ажлын зардлаас санхүүжих төсөл, арга хэмжээний жагсаалтыг 1 дүгээр хавсралт ёсоор баталсугай.

2. Батлагдсан төсөл, арга хэмжээг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралт ёсоор байгуулсугай.

3. Төсөл, арга хэмжээг гүйцэтгэх гүйцэтгэгчийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу сонгон шалгаруулахыг Үнэлгээний хороо /М.Гансэлэм/-нд даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2020 оны 02 сарын 04-ний өдрийн
Д/Н/Д/Г/М тушаалын Д/Г/М хавсралт



НОГООН БАЙГУУЛАМЖИЙН АРЧИЛГААНЫ
ЗАРДЛААС САНХҮҮЖИХ ТӨСӨЛ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

Д.д	Төсөл, арга хэмжээний нэр, төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Зарцуулах зардал /сая. төгрөг/
1.	Гоёл чимэглэлийн гацуур мод худалдан авах ажил	ширхэг	1000	200,0
2.	Мод, бут сөөг хэлбэржүүлэх багаж, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл худалдан авах ажил	Ком	5	100,0
3.	Том оврын нарс, гоёлын гацуур мод тарих, арчлах ажил			
	а/. 4,0-6,0 метрийн өндөртэй том оврын нарс мод тарих, арчлах	ширхэг	1000	380,0
	б/. 1,8-2,0 метрийн өндөртэй гацуур мод тарих, арчлах	ширхэг	1000	200,0
	ДҮН /сая төгрөг/			880,0

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2020 оны 04 сарын 04 өдрийн
... тушаалын ... хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Үнэлгээний хорооны дарга:	М.Гансэлэм	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Гишүүд:	Д.Сүхбат	Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн Ногоон байгууламжийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн
	Д.Нааяа	Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн Ногоон байгууламжийн мэргэжилтэн
	Т.Мөнхнасан	Улаанбаатар хот.Сүхбаатар дүүргийн 3 дугаар хорооны иргэн/зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга:	Л.Баатарцогт	Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн Ногоон байгууламжийн асуудал хариуцсан мэргэжилтэн